



УРИЛГА

Эрхэм хүндэттаныг

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсэг, ажлын албанаас зохион байгуулж буй “2014 онд ОУИТБС-ын тайлангаа чанартай гаргацгаая” онол, практик хослуулсан сургалтанд урьж байна.

Сургалт 2014 оны 3 дугаар сарын 20-ны Пүрэв гаригт Засгийн газрын 11-р байр /хуучнаар Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын/ дугуй танхимд 09:00 – 13:00 цагт болно.

Сургалттай холбоотой лавлах утас: 70110525, eiti.communication@gmail.com

БАТЛАВ. ЕРӨНХИЙ САЙДЫН АХЛАХ ЗӨВЛӨХ, ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ГАНСҮХ

Хөтөлбөр

Сургалтын уриа: 2014 онд ОУИТБС-ын тайлангаа чанартай гаргацгаая!

Сургалтын зорилго: “Компаниудын ОУИТБС-ын тайлан, Монголын ОУИТБС-ын жилийн нэгтгэл тайлангийн чанарыг сайжруулах, тулгарч буй бэрхшээлийг багасгахад хамтран ажиллах”

Дэд зорилтууд:

1. ОУИТБС-ын тайлан гаргахад анхаарах асуудлуудыг танилцуулах, татвар, төлбөр, хандивыг буруу ангилхаас сэргийлэх, бүртгэлтэй холбоотой алдааг багасгах
2. Нэгтгэлийн явцад аудитортой харилцах, тайлбар өгөх, ОУИТБС-ын ач холбогдлыг ойлгуулах, нэгтгэлийн ажлын хугацааг баримтлахад нягтлан бодогч нарын анхаарах асуудлуудыг танилцуулах
3. ОУИТБС-ын тайланд зориулж тусгай журнал хөтөлдөг Бороо гоулд ХХК-ийн туршлагыг сурталчилах, бусад компаниудад үлгэр болгох
4. 2012 оны нэгтгэлийн тайланд аудит хийсэн Далайван аудит ХХК-ийн төлөөлөл өнгөрсөн жил гарсан зөрүүнүүд, цаашид анхаарах асуудлуудыг танилцуулах
5. Сургалтад зориулсан танилцуулга, компаниудын асуулт, хариулт, саналыг нэгтгэн гарын авлага бэлтгэн сургалтанд ирээгүй, хамрагдаагүй болон бусад компаниудад хүргүүлэх, цахим хуудсанд байршуулах

Хүлээгдэж буй үр дүн:

1. 2013 оны Монголын ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн чанар сайжирсан байна.
2. Жил бүрийн нэгтгэл тайлангаар нотлогддог нягтлан бодох бүртгэлийн алдаа багасна.
3. Компаниудын нягтлан бодогч нарт бүртгэлээ үнэн зөв, чанартай хийхэд төрийн байгуулагуудын төлөөллөөс шинэ мэдээлэл олж авах, томоохон компаниудын сайн туршлагаас суралцах боломж нээгдэнэ.

Оролцогчид: 2012 оны нэгтгэл тайланд хамрагдсан, тайлбарлагдаагүй зөрүү ихтэй олборлох үйлдвэрлэлийн 100 компанийн нягтлан бодогчид

Цагийн хуваарь	Агуулга	Илтгэгч
09:00 – 09:10	Нээлт: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон	
09:10 – 09:20	Оролцогчидтой танилцах, сургалтын зорилго, хөтөлбөр, хүлээж буй үр дүнг танилцуулах	Б.Дэлгэрмаа
09:20 - 09:40	ОУИТБС-ын хэрэгжилт, шинэ хандлага Асуулт, хариулт	Ш.Цолмон
09:40 – 10:00	ОУИТБС-ын компаниудын оролцоо, ач холбогдол Асуулт, хариулт	Б.Батбилэг МУУҮА-ий менежер
10:00 – 10:20	ОУИТБС-ын иргэний нийгмийн оролцоо, ач холбогдол Асуулт, хариулт	Н.Баярсайхан ТАН эвслийн зохицуулагч
10:20 – 10:40	ОУИТБС-ын тайлангийн маягт, 2012 оны нэгтгэлийн тайлангийн онцлох тоон мэдээ Асуулт, хариулт	Б.Дэлгэрмаа АА-ны харилцааны мэргэжилтэн
10:40 – 11:00	ОУИТБС-ын тайлангийн маягтад тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын хэсгийг бөглөхөд анхаарах асуудлууд Асуулт, хариулт	АМГ-ын мэргэжилтэн Д.Мөнхсайхан
11:00 – 11:20	Цайны завсарлага	
11:20 – 11:40	ОУИТБС-ын тайлангийн татвар, төлбөрийн ангиллууд, тайлан гаргахад анхаарах асуудлууд Асуулт, хариулт	ТЕГ-ын ТУБ Д.Энхтуяа
11:40 – 12:00	Мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгийн бүртгэлийн асуудлууд Асуулт, хариулт	Сангийн яамны НББГ-ын мэргэжилтэн Г.Зулай
12:00 – 12:20	Бороо гоулд ХХК-ийн ОУИТБС-ын тайлангийн маягтад зориулж хөтөлж буй бүртгэлтэй танилцах, туршлага солилцох Асуулт, хариулт	Бороо гоулд ХХК- ын татварын ахлах нягтлан бодогч П.Болормаа
12:20 – 12:40	2012 оны аудитын нэгтгэлд компаниудын оролцсон байдал, цаашид анхаарах асуудлууд	Далайван аудит ХХК-ийн ерөнхий захирал Б.Жигдэн, ахлах аудитор Б.Гантулга
12:40 - 13:10	Аудитын нэгтгэлтэй холбоотой компаниудаас өгөх санал, хэлэлцүүлэг	
13:10 – 13:20	Сургалтын үр дүнг дүгнэх, хаалт	Ш.Цолмон

ОУИТБС-ын ажлын хэсэг, ажлын алба